

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/261/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: [rsamongolia@gmail.com](mailto:rsamongolia@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

᠒᠐᠒4.0᠒.25 № ᠐1/18᠑  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ С.ХҮРЭЛБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 12 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж 92,5 хувиар хэрэгжүүлсэн байна

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

01᠒᠑᠒᠐435

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	127,805,481.09	306,534,187.78
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	51,827,012.93	205,055,388.73
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	51,827,012.93	205,055,388.73
9	Төгрөг	51,827,012.93	205,055,388.73
10	Төрийн сангийн харилцах	51,827,012.93	205,055,388.73
27	АВЛАГА	-	11,137,460.89
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	10,846,160.89
34	Бусад авлага	-	291,300.00
35	Байгууллагаас авах авлага	-	10,200.00
36	Хувь хүмүүсээс авах авлага	-	281,100.00
60	БАРАА МАТЕРИАЛ	75,978,468.16	90,341,338.16
61	Түүхий эд материал	45,363,642.26	62,117,852.26
62	Тусгай зориулалттай материал	44,722,042.26	61,476,252.26
63	Эм боох материал	641,600.00	641,600.00
66	Хангамжийн материал	30,614,825.90	28,223,485.90
71	Барилгын засварын материал	10,273,170.00	10,270,430.00
72	Хүнсний материал	5,504,600.00	3,116,000.00
73	Бусад хангамжийн материал	14,837,055.90	14,837,055.90
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,586,573,731.26	3,630,779,672.16
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,586,573,731.26	3,630,779,672.16
108	Биет хөрөнгө	3,505,673,731.26	3,549,879,672.16
109	Барилга, байгууламж	3,440,638,857.82	3,468,412,857.82
110	Хуримтлагдсан элэгдэл	(265,309,972.16)	(322,322,630.24)
111	Авто тээврийн хэрэгсэл	8,200,000.00	8,200,000.00
112	Хуримтлагдсан элэгдэл	(8,200,000.00)	(8,200,000.00)
113	Машин, тоног төхөөрөмж	179,172,167.00	281,578,607.00
114	Хуримтлагдсан элэгдэл	(44,749,381.29)	(83,384,208.62)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	187,021,233.92	222,589,333.92
116	Хуримтлагдсан элэгдэл	(61,330,209.37)	(85,136,989.72)
117	Зам гүүрийн барилга байгууламж	74,546,000.00	74,546,000.00
118	Хуримтлагдсан элэгдэл	(23,212,666.72)	(25,546,000.06)
122	Бусад үндсэн хөрөнгө	18,897,702.06	19,142,702.06
126	Биет бус хөрөнгө	80,900,000.00	80,900,000.00
127	Програм хангамж	775,000.00	775,000.00
128	Хасагдуулга	(775,000.00)	(775,000.00)
129	Бусад биет бус хөрөнгө	80,900,000.00	80,900,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,714,379,212.35	3,937,313,859.94

138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	19,716,351.00	22,796,752.00
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,716,351.00	22,796,752.00
164	Өглөг	19,716,351.00	22,796,752.00
166	Бараа үйлчилгээний зардлын өглөг	19,716,351.00	22,540,100.00
170	Бусад өглөг	-	256,652.00
171	Байгууллагад төлөх өглөг	-	246,652.00
172	Хувь хүмүст төлөх өглөг	-	10,000.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	3,694,662,861.35	3,914,517,107.94
215	Засгийн газрын хувь оролцоо	3,694,662,861.35	3,914,517,107.94
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГ Сан/ орон нутгийн сан	383,740,312.86	383,740,312.86
217	Өмч: -Төрийн өмч	383,740,312.86	383,740,312.86
223	Хуримтлагдсан үр дүн	1,670,635,424.90	1,890,489,671.49
224	Өмнөх үеийн үр дүн	1,670,635,424.90	1,670,635,424.90
225	Тайлант үеийн үр дүн	-	219,854,246.59
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,640,287,123.59	1,640,287,123.59
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	3,714,379,212.35	3,937,313,859.94

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,331,906,447.40	1,666,208,728.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,532,347.40	142,189,928.00
77	Нийтлэг татварын бус орлого	52,032,347.40	142,189,928.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	52,032,347.40	142,189,928.00
82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,495,300.00	2,938,248.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	49,537,047.40	139,251,680.00
99	Тусламжийн орлого	2,500,000.00	-
100	Хандив тусламж /дотоод/	2,500,000.00	-
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	318,000,200.00	1,524,018,800.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,261,871,600.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,261,871,600.00
119	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	959,373,900.00	-
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	88,919,200.00	-
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	88,919,200.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	229,081,000.00	262,147,200.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	229,081,000.00	262,147,200.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,318,075,587.57	1,446,354,481.41
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,318,075,587.57	1,446,354,481.41
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,184,527,853.57	1,401,794,366.87
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	683,142,942.61	803,626,924.20
151	Цалин	511,693,640.39	665,014,463.65

152	Нэмэгдэл цалин	156,419,095.22	138,612,460.55
154	Урамшуулал	15,030,207.00	-
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,091,564.46	113,933,067.79
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	58,521,560.19	73,020,384.64
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	6,780,086.83	5,761,326.20
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5,417,269.33	4,582,661.18
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,306,695.40	1,659,480.36
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	13,065,952.71	28,909,215.41
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,957,351.00	263,768,382.46
165	Гэрэл цахилгааны зардал	12,834,759.00	12,448,067.04
166	Түлш, халаалтын зардал	193,122,592.00	251,320,315.42
167	Цэвэр, бохир усны зардал	1,000,000.00	-
170	Хангамж, бараа материалын зардал	8,351,150.00	10,615,040.00
171	Бичиг хэргийн материал	3,419,350.00	4,517,540.00
172	Тээвэр, шатахууны зардал	4,931,800.00	6,097,500.00
181	Нормативт зардал	63,308,646.00	65,254,972.00
182	Эм	1,114,750.00	-
183	Хоол	56,773,796.00	62,104,172.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,420,100.00	3,150,800.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	1,495,180.00	3,145,640.00
189	Урсгал засвар	1,495,180.00	3,145,640.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,879,100.00	5,610,600.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,495,300.00	-
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	3,383,800.00	5,610,600.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	130,301,919.50	135,839,740.42
210	Бараа үйлчилгээний бусад зардал	18,974,930.00	9,617,201.32
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,823,170.00	3,260,000.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	109,503,819.50	122,962,539.10
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	133,547,734.00	44,560,114.54
228	Бусад урсгал шилжүүлэг	133,547,734.00	44,364,248.00
232	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,178,534.00	44,364,248.00
234	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэвэр	26,805,800.00	-
235	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	59,563,400.00	-
242	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	195,866.54
245	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	195,866.54
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	13,830,859.83	219,854,246.59
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	13,830,859.83	219,854,246.59

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,279,869,400.00	1,526,957,048.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,495,300.00	2,938,248.00
78	Нийтлэг татварын бус орлого	2,495,300.00	2,938,248.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,495,300.00	2,938,248.00
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,495,300.00	2,938,248.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,277,374,100.00	1,524,018,800.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,261,871,600.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,261,871,600.00
118	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	959,373,900.00	-
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	88,919,200.00	-
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	88,919,200.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	229,081,000.00	262,147,200.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	229,081,000.00	262,147,200.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,191,421,887.07	1,373,672,672.20
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,191,421,887.07	1,373,672,672.20
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,060,590,907.07	1,335,919,105.66
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	683,142,942.61	820,832,564.90
151	Үндсэн цалин	511,693,640.39	547,198,819.99
152	Нэмэгдэл	156,419,095.22	242,917,263.59
154	Үр дүнгийн урамшуулал	15,030,207.00	30,716,481.32
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	85,091,564.46	104,602,787.98
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	58,521,560.19	70,256,957.91
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	6,780,086.83	9,455,900.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5,417,269.33	7,564,400.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,306,695.40	1,891,200.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	13,065,952.71	15,434,330.07
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	187,241,000.00	260,951,333.46
165	Гэрэл цахилгааны зардал	12,834,759.00	12,448,067.04
166	Түлш, халаалтын зардал	173,406,241.00	248,503,266.42
167	Цэвэр, бохир усны зардал	1,000,000.00	-
181	Нормативт зардал	64,026,200.00	66,525,620.00
183	Хоол, хүнс	64,026,200.00	66,525,620.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
189	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	6,615,100.00	10,749,648.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	2,495,300.00	2,938,248.00
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,119,800.00	7,811,400.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	33,474,100.00	71,257,151.32
209	Бараа үйлчилгээний бусад зардал	22,591,800.00	59,548,301.32
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	10,882,300.00	11,708,850.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130,830,980.00	37,753,566.54

225	Бусад урсгал шилжүүлэг	130,830,980.00	37,557,700.00
229	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	44,461,780.00	37,557,700.00
231	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн т	26,805,800.00	-
232	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	59,563,400.00	-
239	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	195,866.54
242	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	195,866.54
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	88,447,512.93	153,284,375.80
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН	36,620,500.00	-
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,620,500.00	-
263	Дотоод эх үүсвэрээр	36,620,500.00	-
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зард	36,620,500.00	-
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(36,620,500.00)	-
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	51,827,012.93	153,284,375.80
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэ	0.00	51,827,012.93
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлд	51,827,012.93	205,055,388.73

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	383,740,312.86	1,640,287,123.59	1,670,635,424.90	3,694,662,861.35
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	383,740,312.86	1,640,287,123.59	1,670,635,424.90	3,694,662,861.35
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	383,740,312.86	1,640,287,123.59	1,670,635,424.90	3,694,662,861.35
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			219,854,246.58	219,854,246.58
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	383,740,312.86	1,640,287,123.59	1,890,489,671.48	3,914,517,107.94

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	51,827,012.93	(51,827,012.93)	0
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,579,181,200.00	1,462,173,204.34	117,007,995.66	92.59
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,579,181,200.00	1,462,173,204.34	117,007,995.66	92.59
4	Бараа, үйлчилгээний зардал	1,519,854,600.00	1,338,246,304.34	181,608,295.66	88.05

5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	972,495,000.00	820,997,564.90	151,497,435.10	84.42
6	Үндсэн цалин	654,020,100.00	547,363,819.99	106,656,280.01	83.69
7	Нэмэгдэл	277,301,100.00	242,917,263.59	34,383,836.41	87.6
9	Урамшуулал	41,173,800.00	30,716,481.32	10,457,318.68	74.6
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,562,100.00	104,602,787.98	16,959,312.02	86.05
12	Тэтгэврийн даатгал	82,662,200.00	70,256,957.91	12,405,242.09	84.99
13	Тэтгэмжийн даатгал	9,725,000.00	9,455,900.00	269,100.00	97.23
14	ҮОМШӨ ний даатгал	7,780,000.00	7,564,400.00	215,600.00	97.23
15	Ажилгүйдлийн даатгал	1,945,000.00	1,891,200.00	53,800.00	97.23
16	Эрүүл мэндийн даатгал	19,449,900.00	15,434,330.07	4,015,569.93	79.35
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	261,147,200.00	260,951,333.46	195,866.54	99.92
18	Гэрэл цахилгаан	12,443,900.00	12,448,067.04	(4,167.04)	100
19	Түлш, халаалт	248,503,300.00	248,503,266.42	33.58	100
20	Цэвэр, бохир ус	200,000.00	-	200,000.00	0
30	Нормативт зардал	79,278,100.00	66,525,620.00	12,752,480.00	83.91
32	Хоол, хүнс	79,278,100.00	66,525,620.00	12,752,480.00	83.91
34	Эд хогшил худалдан авах	1,000,000.00	1,000,000.00	-	100
38	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	10,996,300.00	10,749,648.00	246,652.00	97.76
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,184,900.00	2,938,248.00	246,652.00	92.26
49	Мэдээллийн технологийн зардал	7,811,400.00	7,811,400.00	-	100
53	Бараа үйлчилгээний бусад зардал	73,375,900.00	73,419,350.00	(43,450.00)	100.1
54	Бараа үйлчилгээний бусад зардал	61,658,900.00	62,720,350.00	(1,061,450.00)	101.7
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,717,000.00	10,699,000.00	1,018,000.00	91.31
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,326,600.00	123,926,900.00	(64,600,300.00)	208.9
70	Бусад урсгал шилжүүлэг	59,326,600.00	123,926,900.00	(64,600,300.00)	208.9
74	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	59,326,600.00	37,557,700.00	21,768,900.00	63.31
76	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	26,805,800.00	(26,805,800.00)	0
77	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	-	59,563,400.00	(59,563,400.00)	0
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,527,203,700.00	1,615,876,248.00	(88,672,548.00)	105.8
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,265,056,500.00	1,261,871,600.00	3,184,900.00	99.75
99	Улсын төсвөөс санхүүжих	1,265,056,500.00	1,261,871,600.00	3,184,900.00	99.75
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИ	262,147,200.00	262,147,200.00	-	100
104	Орон нутгийн төсвөөс	262,147,200.00	262,147,200.00	-	100
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	2,938,248.00	(2,938,248.00)	0
111	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүү	-	2,938,248.00	(2,938,248.00)	0
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	88,919,200.00	(88,919,200.00)	0
124	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	88,919,200.00	(88,919,200.00)	0
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	51,827,012.93	(51,827,012.93)	0
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	205,055,388.73	(205,055,388.73)	0
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	0
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	52.00	52.00	-	100
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100
135	Гүйцэтгэх ажилтан	32.00	32.00	-	100
136	Үйлчлэх ажилтан	19.00	19.00	-	100

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургууль нь эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, хариуцлагатай, бие даан суралцах, амьдрах чадвартай иргэн төлөвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус байгууллага нь Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оныг "Сургуулийн менежментийг сайжруулах" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 12 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 92,5 хувиар биелүүлж ажилласан байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургууль нь 48 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэн хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сарын 7 өдөр аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдаж, 89,2 хувьтай үнэлэгдсэн.

2023 оны 11 дүгээр сарын 1 өдөр сумын хяналт шалгалт үнэлгээний хорооны шалгалтаар 88,9 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 222,934.6 мянган төгрөгөөр буюу 6% хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	51,827.0	205,055.4	153,228.3
Авлага		11,137.5	11,137.5
Урьдчилгаа			
Бараа материал	75,978.5	90,341.3	14,362.8
Үндсэн хөрөнгө	3,586,573.7	3,630,779.7	44,205.9
Нийт хөрөнгө	<b>3,714,379.2</b>	<b>3,937,313.8</b>	<b>222,934.6</b>
Өр төлбөр	19,716.3	22,796.7	2,823.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	383,740.3	383,740.3	
Дахин үнэлгээний нэмэгдэл	1,640,287.1	1,640,287.1	
Хуримтлагдсан үр дүн	1,670,635.4	1,890,489.7	219,854.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>3,714,379.2</b>	<b>3,937,313.8</b>	<b>222,934.6</b>

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 153,228.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон тоо хэмнэж үндсэн цалин, нэмэгдэл зэргийг хэмнэснээс шалтгаалан мөнгөн хөрөнгө данс өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 11,137.5 мянган төгрөг байгаа нь ХАОАТ-г илүү шилжүүлснээс болж авлага үүссэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 14,362.8 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар сургуулийн ойтой холбогдон төгсөгчдөөс 6,314.1 мянган төгрөгийн бараа материал хүлээн авсанаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс 44,205.9 мянган төгрөгөөр өссөн нь: Төгсөгчдөөс 44,178.5 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, Аймгийн Боловсролын газраас багш бүр компьютер хөтөлбөрөөр 23,374.0 мянган төгрөгийн 26 ширхэг зөөврийн компьютер тус тус хүлээн авсанаас шалтгаалсан байна. Мөн сумын ИТХ-н 2023 оны 8 дугаар сарын 15-ний 03 тоот тогтоолоор тоног төхөөрөмж 634.9 мянган төгрөг, тавилга эд хогшил 540.0 мянган төгрөгийн хөрөнгийг актласан байна.

Өглөг дансны үлдэгдэл 2,823.7 мянган төгрөгөөр өссөн нь халаатын мкв үнийн зөрүүнээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,317,034.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 262,147.2 мянган төгрөг нийт зарлагыг 1,579,181.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 1,579,181.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,579,181.4 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,579,181.4 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,462,173.2 мянган төгрөг буюу 92,5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 117,007.9 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалинг 106,656.2 мянган төгрөгөөр, нэмэгдэл цалинг 34,383.8 мянган төгрөгөөр тус тус илүү зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	71802-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	3,124.5	3,124.5		100%
2	80312-Сургалт семинар	1,562.3	1,562.0	0.3	99,9%
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	3,899.3	3,899.3		100%
4	81801-Үдийн цай хөтөлбөр	59,326.6	37,557.5	21,769.1	63,3%
5	81806- Дотуур байрны үйлчилгээ	123,595.1	106,803.2	16,791.8	86,4%
6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	32,900.7	32,900.7		100%
7	81823- Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	7,509.2	5,267.8	2,241.3	70,1%
8	81827- Бичиг үсгийн боловсрол олгох	9,660.1	8,453.2	1,206.8	87,5%

9	81834- Боловсролын стандарт	878,778.2	683,913.4	194,864.7	77,8%
10	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	193,342.6	179,640.9	13,701.7	92,9%
11	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	150.7		150.7	
12	81848- Сурах бичгийн түрээс	3,184.9	2,938.2	246.6	92,2%
13	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	262,147.2	261,951.3	195.8	99,9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургууль нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71802-80226	2023-12-31	Байр ашиглалтын үйлчилгээ	100%	3,124.5	3,124.5
2	71802-80312	2023-12-31	Сургалт семинар	99,9%	1,562.3	1,562.0
3	71802-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	100%	3,899.3	3,899.3
4	71802-81801	2023-12-31	Үдийн цай хөтөлбөр	63,3%	59,326.6	37,557.5
5	71802-81806	2023-12-31	Дотуур байрны үйлчилгээ	86,4%	123,595.1	106,803.2
6	71802-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%	32,900.7	32,900.7
7	71802-81823	2023-12-31	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	70,1%	7,509.2	5,267.8
8	71802-81827	2023-12-31	Бичиг үсгийн боловсрол олгох	87,5%	9,660.1	8,453.2
9	71802-81834	2023-12-31	Боловсролын стандарт	77,8%	878,778.2	683,913.4
10	71802-	2023-12-31	Сургалтын хэвийн	92,9%	193,342.6	179,640.8

	81835		үйл ажиллагааг хангах			
11	71802-81844	2023-12-31	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн		150.7	
12	71802-81848	2023-12-31	Сурах бичгийн түрээс	92.2%	3,184.9	2,938.2

Бичиг үсгийн боловсрол олгох арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь сургалтад хамрагдах ирц муугаас нөлөөлсөн. Сурах бичгийн түрээс арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь сурах бичиг түрээслэх сурагчид бага байсан нь нөлөөлсөн. Үдийн цай арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь сурагчдын ирц хангалтгүйгээс шалтгаалсан байна. Боловсролын стандарт арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь багш ажилчдын орон тоо дутуу байгаагаас шалтгаалсан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цахим дэлгүүрээс худалдан авалт байхгүй. 3 удаа тендер зарласан боловч оролцогч байхгүйн улмаас шууд худалдан авдаг. Мөн Монгол Шуудан ХХК, НИК, Юнител, Скайтел зэрэг аж ахуйн нэгжүүдтэй шууд гэрээтэй ажилласан байна. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлвөлгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 965,000.0 мянган төгрөгнөөс 2.0 хувиар буюу 19,300.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15,440.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 151,497.4 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 12,752.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 148 мэдээлэлийг хугацаанд нь мэдээлж, 11 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “Өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулав.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 4 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь Өмнөх аудитаар 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Акт</b>					
<b>Албан шаардлага</b>					
<b>Зөвлөмж</b>	1	19,716.3	1	19,716.3	100%
<b>Нийт дүн</b>	1	19,716.3	1	19,716.3	100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал ажиглагдаагүй

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 37,736.8 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 4,000.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 10,846.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 22,890.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой.

Хангамжийн бараа материал дансанд бүртгэгдсэн 4,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг залруулан үндсэн хөрөнгө дансанд бүртгэх. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

## 5.1 Төлбөрийн акт

### 1. Авлагын данстай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

ХХОАТ-г давхардуулан шилжүүлсэн 10,846.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх” мөн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна. .

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

### 5.3 Зөвлөмж

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Шатахууны зарцуулалтын тайланг шалгахад жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүйн улмаас 94.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2013 оны 390 тоот тушаалын 1-5 дугаар хавсралтаар батлагдсан нормыг мөрдөж ажиллах гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байх

#### Өгсөн зөвлөмж:

Цаашид өр, авлага үүсгэхгүй ажиллах

#### 2. Өглөгийн данстай холбоотой асуудал

Халаалтын зардал дутуу төлсөн өглөг 22,796.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх” заалт, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Цаашид өр, авлага үүсгэхгүй ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх төлбөрийн акт болон зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хангамжийн бараа материал дансанд бүртгэгдсэн 4,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг залруулан үндсэн хөрөнгө дансанд бүртгэх	1	4,000.0					1	4,000.0				
Дүн	1	4,000.0					1	4,000.0				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны зарцуулалтын тайланг шалгахад жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй	1	94.0					1	94.0				
ХХОАТ-г давхардуулан шилжүүлсэн	1	10,846.1	1	10,846.1								
Халаалтын зардал дутуу төлсөн өглөг	1	22,796.7					1	22,796.7				
Дүн	3	33,736.8	1	10,846.1			2	22,890.7				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)